



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2026 оны I улирал

САХИЛ АВААДШАЛ ДОРДОВ

САХИЛ АВААД ШАЛ ДОРДОВ

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22 хувиар нэмэгдлээ. Эдийн засгийн салбарууд өсөлттэй байгаа нь чанаргүй зээлийн хэмжээ бага түвшинд байхад нөлөөлж байна. Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн банкны зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Төлбөрийн тэнцэл ашигтай байхад урсгал данс ашигтай гарсан нь нөлөөллөө. Нөгөө талаас импортын хэмжээ буурч байгаа нь төлбөрийн тэнцэл ашигтай байхад нөлөөлөв. Уул уурхайн гаралтай түүхий эдийн экспорт нэмэгдэж буй нь экспортын орлогыг нэмэгдүүлж, валютын нөөцийг нэмэгдэх хүчин зүйл болов. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт сайжирсны нөлөөгөөр төсвийн орлого нэмэгдсэн ч төсвийн урсгал зардал, хөрөнгийн зардлын өсөлт өндөр байгаа нь төсвийн тэнцэл алдагдалтай байх нөхцөлийг бүрдүүллээ.

Уул уурхайн салбар, түүнийг дагасан тээвэр, логистик, үйлчилгээний салбар өсөлттэй байгаа нь эдийн засаг 7.9 хувиар тэлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Барилга, боловсруулах болон ХАА-н салбарын өсөлт тогтвортой хэвээр байна. Нийлүүлэлтийн гаралтай бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нэмэгдсэн нь инфляцын түвшин нэмэгдэхэд нөлөөлж байна.


Эдийн засгийн өсөлт хүлээлтээс давсан хэдий ч нөгөө л уул уурхайн салбараас шалтгаалан өсжээ. Одоогийн эдийн засгийн нөхцөл байдалд тодорхой бус байдлууд улам бүр нэмэгдэж буй тул уул уурхайн салбараас бусад салбарын өсөлтийг тогтвортой хадгалахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг авахгүй л бол “Сахил аваад шал дордов” гэдэг зүйл болох вий.



Хэрэглээний зээлийн шаардлагыг нэмэгдүүлсэн нь иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтөд сөргөөр нөлөөлжээ.

Цалин, тэтгэврийн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар буурчээ.
Хадгаламж барьцаалсан зээл 5 хувиар нэмэгджээ.
Малчдын хэрэглээний зээл огцом өсжээ.

Иргэдийн зээл олголт, жил бүрийн I улирал



Банкны шинээр олгосон зээл

. Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг

Иргэдийн зээл
1%
Нэмэгджээ.

2026 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Бизнесийг дэмжих зээл
нэмэгдэж иргэдийн
хэрэглээний зээл буурлаа.



Банкнудын чанаргүй зээлийн
багц буурчээ.



Системийн нөлөө бүхий 5 банкны
санхүүгийн үзүүлэлт харьцангуй
сайн байна.



Олон нийтэд нээлттэй болсон
банкнуд 2025 оны ашгаас 596
тэрбум төгрөгийн ногдол
ашгийг хуваарилжээ.



Хүүгийн түвшин харьцангуй
тогтвортой байна.




Төгрөгт итгэх итгэл хэвээр
байгаа нь төгрөгийн хадгаламж
нэмэгдэхэд нөлөөлжээ.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2026 он I улирал

Эдийн засгийг дэмжихэд чиглэсэн бизнесийн зээл олголт өндөр хэвээр байна.

Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн бизнесийн зээлийн өсөлт үргэлжилсээр байна. Иргэдийн зээлийн шаардлагыг нэмэгдүүлсэн нь иргэдэд олгох зээлийн өсөлтийн хурдыг сааруулав.



Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.


+17%

Зээлийн үлдэгдэл өсөв.

Эдийн засгийн салбаруудыг дэмжихэд чиглэсэн зээл олголт үргэлжилж байна

Уул уурхай, барилга, худалдаа болон боловсруулах салбарын зээл олголт нэмэгджээ.
Үйлчилгээ болон ХАА-н бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн зээлийн хэмжээ буурсан.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн I улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг

Шинээр олгосон зээл

8%

өсжээ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээлийн хэмжээ
буурчээ.

5%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Зээлийн багцын чанар сайн байна.


Иргэдийн хэрэглээний зээлийн чанаргүйдэл нэмэгджээ.

Эдийн засаг сэргэж байгаа нь бизнесийн зээлийн чанар сайжрахад эергээр нөлөөлж байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Банкны жигнэсэн дундаж хүү


Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Зээлийн хүү

17.6%

Хүү тогтвортой байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд гадаад болон дотоод эдийн засгийн шокоос хамгаалах зорилгоор бодлогын хүүг өндөр байлгаж байгаа ч хүү тогтвортой түвшинд байна.




Эдийн засгийн нөхцөл дахь тодорхой бус байдлаас шалтгаалан хугацаатай хадгаламж болон валютын харилцахад илүү итгэж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад валютын харилцах 38 хувиар нэмэгдлээ.
Төгрөгийн хадгаламжийн бодит өгөөж эерэг байгаа нь иргэдийн төгрөгийн хадгаламж нэмэгдэхэд нөлөөллөө.

Банкны эх үүсвэр, жил бүрийн I улиралд

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

22%

НЭМЭГДЭВ

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2026 он I улирал

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив өсөв.

18%

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 11.5 их наяд төгрөгөөр нэмэгджээ.


Банкны салбарын активын өсөлт үргэлжилсээр байна.

Хаан банкны актив 28 хувиар, Голомт банк болон Төрийн банкны актив тус бүр 18 хувиар нэмэгджээ.

ХХБ болон Хас банкны актив 10 хувиар өсжээ.

Банкуудын актив жил бүрийн I улирал


Их наяд ₮



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.4 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны эх үүсвэр 23 хувиар, Голомт банкны эх үүсвэр 19 хувиар нэмэгджээ.
Бусад банкны эх үүсвэрийн өсөлт үргэлжилсээр байна.

Банкуудын эх үүсвэр жил бүрийн I улирал



Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкнудын эх үүсвэр нэмэгдэв.

17%

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс
гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний
өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг
хэлдэг.

Банкнудын өөрийн
хөрөнгийн хүрэлцээний
дундаж

17%


Эх сурвалж: Банкнудын аудитлагдаагүй тайлан

Банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээ өндөр байна.

Банкууд эдийн засгийн салбаруудыг дэмжих хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкууд өөрийн ашгаас 596 төгрөгтэй тэнцэх ногдол ашиг хуваарилжээ.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн I улирал




2024	2025	2026	2024	2025	2026	2024	2025	2026	2024	2025	2026	2024	2025	2026
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Банкнудын олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна.

Банкнудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт буурсан хэдий ч хангалттай хэмжээний хөрвөх чадвартай байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн I улирал



Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж

39%

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


2026 оны I улирал: Эдийн засгийн өсөлт 7.9 хувьтай гарлаа. Уул уурхайн салбар эрчимжиж, түүнийг дагаад тээвэр, логистик болон үйлчилгээний салбарын өсөлт үргэлжилсэн нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүллээ. Боловсруулах болон ХАА-н салбарын үйлдвэрлэл тогтвортой байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Урсгал данс ашигтай байсан нь төлбөрийн тэнцэл ашигтай гарахад чухал нөлөө үзүүллээ.

Төлөв байдал: Эдийн засгийн үзүүлэлтүүд төсөөллөөс харьцангуй сайн байна. Учир нь уул уурхайн гол бүтээгдэхүүн болон нүүрс болон цайрын хүдэр, баяжмалын экспорт цаашид нэмэгдэж гадаад валютын орох урсгал тасралтгүй байх хүлээлтийг үүсгэлээ. Гэвч дэлхийн зах зээл дээрх тодорхой бус байдал, геополитикийн асуудлаас үүдэлтэй нефтийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх, цаашлаад эдийн засгийн бүхий л салбаруудад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2026 оны эхний улиралд эдийн засаг 7.9 хувиар өсөв.

Уул уурхайн салбар эрчимжиж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлэв. Уул уурхайн салбарын өсөлтийг дагаад тээвэр, логистик болон үйлчилгээний салбар өсөлттэй байлаа.


Хөдөө аж ахуйн болон аж үйлдвэр, барилгын салбарын өсөлт харьцангуй тогтвортой байна.




Гадаад худалдааны тэнцэл эхний улиралд 2.4 тэрбум ам.долларын ашигтай байна.

Нүүрсний биет хэмжээ болон үнийн дүн нэмэгдсэн нь экспортын өсөлтөд эергээр нөлөөллөө.
Зэсийн олборлолт нэмэгдэж зэсийн баяжмалын тоо хэмжээ нэмэгдсэн нь экспортын өсөлтийг дэмжлээ.
Суудлын авто машин, тээврийн хэрэгслийн сэлбэг зэргийн хэрэглээ буурсан нь импорт буурахад нөлөө үзүүлжээ.
Нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ ихэсжээ.

Уул уурхайн салбарын сэргэлт нь экспорт нэмэгдэхэд чухал нөлөө үзүүллээ.




Хөрөнгө оруулалтын болон хэрэглээний бүтээгдэхүүний хэрэглээ буурсан нь импортын хэмжээ буурахад нөлөөлжээ.



Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн нь худалдааны тэнцэл ашигтай гарахад чухал нөлөө үзүүллээ.


сая.доллар




Төлбөрийн тэнцэл 95 сая ам.долларын ашигтай байна.

- Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн нь урсгал данс ашигтай гарахад чухал нөлөө үзүүлээ.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь санхүүгийн данс алдагдалтай гарахад нөлөөлжээ.
- Төгрөгийн бодит ханш чангарч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж эхэлж байна.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл ашигтай байна.




Төсвийн тэнцэл 1,360 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.


Төсвийн орлого нэмэгдэхэд нийгмийн даатгалын орлого, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого нэмэгдсэн нь нөлөөлжээ. Төсвийн хөрөнгийн зардал болон урсгал зардал нэмэгдсэн нь төсвийн зардал өндөр байх шалтгаан болж байна. Үндсэн тэнцэл алдагдалтай болж төсвийн дарамт улам бүр нэмэгдэж байна.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 12 хувиар өсжээ.

ДНБ-д эзлэх хувиар



Нийт төсвийн зарлага өмнөх оны мөн үеэс 18 хувиар нэмэгджээ.



Төсвийн алдагдал нэмэгдэж байна.

